

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Хөвсгөл аймаг 2026 он	Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn Аудитор: Х.Энхтуяа Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026-03-25 № 01/329
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ОТГОНСҮРЭН
ТАНАА**

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр 125.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 20.0 сая төгрөгийн алдааг залруулж, хууль тогтоомжийн хэрэгжилт, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл болон авлага, улс, орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт, худалдан авах ажиллагаа, дотоод хяналттай холбоотой нийт 108.4 сая төгрөгийн 7 зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Цагааннуур сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээг 76.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,050,783.45	1,159,768.78
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	890,593.32	826,125.82
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	45,239.58	133,107.58
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	114,950.54	200,535.39
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		592,786.49	681,458.44
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	592,786.49	681,458.44
7	Биет хөрөнгө		531,147.05	619,825.9
8	Биет бус хөрөнгө	13	61,639.44	61,632.54
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,643,569.94	1,841,227.22
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	25,909.98
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	25,909.98
12	Өглөг		0.0	25,909.98
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,643,569.94	1,815,317.24
14	Засгийн газрын хувь оролцоо		1,643,569.94	1,815,317.24
15	Засгийн газрын оруулсан капитал		225,884.77	225,884.77
16	Хуримтлагдсан үр дүн		1,282,195.54	1,453,942.85
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		135,489.63	135,489.63
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,643,569.94	1,841,227.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,852,380.49	1,686,524.23
2	ТАТВАРЫН ОРЛОГО		516,197.55	535,851.74
3	Орлогын албан татвар		422,491.88	450,784.71
4	Хувь хүний орлогын албан татвар		422,491.88	450,784.71
5	Хөрөнгийн албан татвар		16,300.47	15,184.61
6	Бусад татвар, төлбөр, хураамж		77,405.21	69,882.42
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	94,702.93	1,150,672.49
8	Хөрөнгийн орлого		0.0	5,250
9	Тусламжийн орлого		0.0	936,706.69
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,241,480.01	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,300,836.96	1,506,631.1
12	УРСГАЛ ЗАРДАЛ		1,300,836.96	1,506,631.1
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,210,581.86	1,427,487.8
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		594,845.86	673,637.08

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,896.31	80,506.96
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,412.88	219,087.91
17	Хангамж, бараа материалын зардал	62,771.43	122,412.24
18	Нормативт зардал	1,080	0.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	51,161.55	73,599.99
20	Томилолт, зочны зардал	10,108.5	11,687.48
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,558.44	19,241.93
22	Бараа үйлчилгээний бусад зардал	181,746.88	227,314.22
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,255.1	79,143.29
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	551,543.54	179,893.14
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,159.35	8,145.83
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-2,159.35	-8,145.83
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	549,384.19	171,747.31

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,765,141.6	1,671,076.31
2	ТАТВАРЫН ОРЛОГО	516,197.55	535,851.74
3	Орлогын албан татвар	422,491.88	450,784.71
4	Хөрөнгийн албан татвар	16,300.47	15,184.61
5	Бусад татвар, төлбөр, хураамж	77,405.21	69,882.42
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,805.29	8,944.48
7	Газрын төлбөр	10,153.84	4,458.28
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	56,446.08	56,479.66
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,464.04	1,135,224.57
10	Нийтлэг татварын бус орлого	7,464.04	13,312.07
11	Хөрөнгийн орлого	0.0	5,250
12	Тусламжийн орлого	0.0	936,706.69
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	179,955.8
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,241,480.01	0.0
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,178,778	1,342,462.68
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,178,778	1,342,462.68
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,602.7	1,263,319.39
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,481.32	673,239.49
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,531.78	79,956.86
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,645.24	235,400.63
21	Хангамж, бараа материалын зардал	68,223	63,243.82

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

22	Нормативт зардал	2,000	1,880
23	Эд хогшил, урсгал засварын зардал	55,839.25	86,394.39
24	Томилолт, зочны зардал	10,108.5	11,687.48
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,730.34	17,991.93
26	Бараа үйлчилгээний бусад зардал	106,043.26	93,524.8
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,175.3	79,143.29
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	586,363.6	328,613.62
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	144,260.6	333,081.13
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	144,260.6	333,081.13
31	Дотоод эх үүсвэрээр	144,260.6	333,081.13
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-144,260.6	-333,081.13
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	60,000
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-60,000
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	442,103	-64,467.5
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	448,490.32	890,593.32
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	890,593.32	826,125.82

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,094,185.75	1,094,185.75
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,094,185.75	1,094,185.75
3	Тайлант үеийн үр дүн	549,384.19	549,384.19
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,643,569.94	1,643,569.94
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,643,569.94	1,643,569.94
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,643,569.94	1,643,569.94
7	Тайлант үеийн үр дүн	171,747.31	171,747.31
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,815,317.24	1,815,317.24

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,201,463.3	1,708,686.1	492,777.2	77.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,607,912.4	1,315,605.0	292,307.4	81.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,506,301.1	1,236,461.7	269,839.4	82.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,956.2	673,239.5	128,716.7	83.9
210101	Үндсэн цалин	734,670.6	444,798.1	289,872.5	60.5

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210102	Нэмэгдэл	43,097.9	201,036.3	-157,938.4	466.5
210104	Урамшуулал	10,958.0	16,297.5	-5,339.5	148.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,229.7	11,107.6	2,122.1	84.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,244.6	79,956.9	20,287.7	79.8
210201	Тэтгэврийн даатгал	68,166.3	57,131.8	11,034.5	83.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,019.6	7,289.1	730.5	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,009.8	3,077.4	932.4	76.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,009.8	2,491.7	1,518.1	62.1
210205	Эрүүл мэндийн даатгал	16,039.1	9,966.9	6,072.2	62.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,706.1	235,400.6	7,305.5	97.0
210301	Гэрэл, цахилгаан	52,110.0	40,387.3	11,722.7	77.5
210302	Түлш, халаалт	180,346.0	187,255.5	-6,909.5	103.8
210303	Цэвэр, бохир ус	10,250.1	7,757.9	2,492.2	75.7
2104	Хангамж, бараа материалын зардал	67,512.3	58,688.6	8,823.7	86.9
210401	Бичиг хэрэг	7,399.9	3,321.7	4,078.2	44.9
210402	Тээвэр, шатахуун	37,800.0	37,235.7	564.3	98.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500.0	2,531.0	969.0	72.3
210404	Ном, хэвлэл	152.4	0.0	152.4	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,060.0	1,754.0	306.0	85.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,600.0	13,846.2	2,753.8	83.4
2105	Нормативт зардал	2,000.0	1,880.0	120.0	94.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.0	1,880.0	120.0	94.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,913.8	67,394.4	25,519.4	72.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000.0	0.0	20,000.0	0.0
210604	Урсгал засвар	72,913.8	67,394.4	5,519.4	92.4
2107	Томилолт, зочны зардал	14,500.0	11,687.5	2,812.5	80.6
210702	Дотоод албан томилолт	14,500.0	11,687.5	2,812.5	80.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,777.0	17,991.9	21,785.1	45.2
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	37,162.8	16,598.5	20,564.4	44.7
210803	Даатгалын үйлчилгээ	364.2	118.2		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600.0	253.5	346.5	42.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250.0	0.0	250.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.0	623.0		
210807	Газрын төлбөр	400.0	398.7	1.3	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,691.1	90,222.4	54,468.8	62.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,191.1	90,062.4	54,128.8	62.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500.0	160.0	340.0	32.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,611.3	79,143.3	22,468.0	77.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,611.3	79,143.3	22,468.0	77.9
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	12,768.0	0.0	12,768.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,143.3	77,143.3	0.0	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,700.0	2,000.0		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	463,550.9	333,081.1	130,469.8	71.9
223001	Бусад хөрөнгө	463,550.9	333,081.1	130,469.8	71.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	130,000.0	60,000.0	70,000.0	46.2

230001	Эргэж төлөгдөх зээл	130,000.0	60,000.0	70,000.0	46.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,201,463.3	1,644,218.7	557,244.6	74.7
122	Тусламжийн орлого	2,201,463.3	1,644,218.7	557,244.6	74.7
122005	Орон нутгийн төсвөөс	1,318,335.2	1,453,675.8	-135,340.6	110.3
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.0	10,533.4	19,466.6	35.1
120010	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	53.7	946.3	5.4
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	668,277.1		668,277.1	0.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	183,851.0	179,955.8	3,895.2	97.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		890,593.3		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		826,125.8		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл /мянган төгрөгөөр/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,777.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,777.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,857.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,555.2
210402	Тээвэр, шатахуун	4,555.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,302.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,302.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,920.1
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	9,920.1
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,777.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,777.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,322.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	455.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Дүгнэлт өгсөн.
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
3	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
4	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 19.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 0.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага, 19.0 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар нийт 20.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 арга хэмжээний 20.0 сая төгрөгийн авлагыг тайланд тусгаагүй.

Аудитаар нийт 108.4 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Цагааннуур сумын орон нутгийн өмчит “Үзэсгэлэнт шишхэд” ХХК-ий 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Төсвийн тухай” хуульд заасан цаглаварт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

2. Илрүүлэлт:

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт орлогын данснаас 2025 онд “Блисс анлимитед” ХХК-д хөрөнгө худалдан авахаар 19.0 сая төгрөгийн гэрээ хийж мөнгийг шилжүүлсэн боловч 10.3 сая төгрөгийн хөрөнгийн хүлээн аваагүй байна. Энэ нь Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлангаар авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулах ажлыг яаралтай зохион байгуулж биелэлтийг ирүүлэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11 “гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх”, “Худалдах худалдан авах” гэрээний 3 дугаар зүйлийн 3.1 “Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид төлбөр төлсний дараа 14 хоногт нийлүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1 “Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа орох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох орлогыг хуулийн дагуу төлнө” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.

1.1 Илрүүлэлт:

Цагааннуур сумын орон нутгийн өмчит “Үзэсгэлэнт шишхэд” ХХК-ий 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Цагааннуур сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудыг нэгтгэлд бүрэн хамруулах

2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй холбоотой

2.1 Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл 6 иргэнтэй холбоотой 28.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

3. Орлогын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Сумын Төрийн сангийн ерөнхий орлогын дансны тайланг журнал бичиж, нягтлан бодох бүртгэл хөтлөхгүйгээр тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.2 "журналд бичих" санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Сумын төрийн сангийн ерөнхий орлогын дансны тайланг гаргаж хэвших

4. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4.3 сая төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх орлогыг 1.9 сая төгрөгөөр, сумын 5-н нэр төрлийн орлогыг 63.5 сая төгрөгөөр нийт 67.7 сая төгрөгөөр орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсвийн орлогыг нэр төрөл бүрээр нь жигд ханган биелүүлэх

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Дотоод хяналтын нэгж нь 2025 онд 6 ажил хийхээр төлөвлөснөөс 2 ажилд хяналтыг хэрэгжүүлээгүй, хяналт хэрэгжүүлсэн 4 ажлын хяналтын тайлан хангалтгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.3. "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамруулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын www.fas.audit.mn цахим системд 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагааннуур сумын ТТЗ	1	20.0	1	20.0			1	20.0				
Дүн	1	20.0	1	20.0			1	20.0	0	0	0	0
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цагааннуур сумын ЗДТГ	1	0.7	1	0.7			1	0.7				
Дүн	1	0.7	1	0.7			1	0.7				
Дүн	2	20.7	2	20.7	0	0	2	20.7	0	0	0	0

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цагааннуур ТТЗ	6	108.4			2	10.3	4	98.1				
Дүн	6	108.4			2	10.3	4	98.1				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цагааннуур сумын ЗДТГ	3	19.0			1		2	19.0				
Дүн	3	19.0			1		2	19.0				
Нийт дүн	9	127.7			3	10.3	6	117.1				

3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Цагааннуур ТТЗ	1	0						1	

Харьяа байгууллагуудын зөрчил								
Дүн	1	0.0					1	0.0
Нийт дүн	1	0.0					1	0.0

АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



Х.ЭНХТУЯА ОГНОО: 2026.03.25

